

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/011/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn  Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn  Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn  Цахим хаяг: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 517

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Захирагчийн 76,828.6 мянган төгрөг, Захирагчийн ажлын албаны 246,478.2 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 150,444.1 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн 2,144.5 мянган төгрөг, нийт 475,895.4 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- ✓ Малын тоо толгойн албан татварын орлогыг дутуу бүрдүүлсэн,
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд тайлант оны малын тоо толгойн албан татварыг дутуу төвлөрүүлсэн,
- ✓ Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг төлөвлөж батлаагүй, чанаргүй зээлийн ангилалд шилжсэн зээлийг эргэн төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй,

- ✓ ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийг холбогдох журмыг зөрчиж илүү дүнгээр олгосон,
- ✓ Үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн цалинд 11,583.6 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас хувцас хэрэглэлд 1,500.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас цол ахиулан амжилт гаргасан бөхөд 1,500.0 мянган төгрөгийн мялаалга, хичээл үйлдвэрлэлийн зардлаас малчдын сургалт, сурталчилгаанд 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- ✓ Ээлжийн амралттай ажилтанд цалин давхардуулан олгосон,
- ✓ Байгууллагын хэрэгцээнд 2 төрлийн интернэт сүлжээг зэрэгцүүлэн ашиглаж мөнгөн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зэрэг зөрчлүүд гарсан байна.  
Энэ нь дараах хууль тогтоомж, тушаал шийдвэрийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- ✓ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;”
- ✓ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна."
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралт “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.5-д “зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх” 7.3-т “Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна”
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам-ын 4.8.13-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь барилга, байгууламжийн төслийн хувьд гэрээний үнийн дүнгийн 30 хувь хүртэл байх бөгөөд тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн дүнгээс ихгүй байна;”
- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна”, 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”
- ✓ Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно."

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,124,376.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 924,006.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 180,370.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 20,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар төлөвлөж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,015,298.5 мянган төгрөг буюу 90.3 хувьтай байна.

#### **Аудитын гол асуудал**

Гурванбаян тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 475,895.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 380,864.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 44,092.6 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1,934.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 49,003.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутгийн төсөвт 254,200.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 253,458.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.7 хувиар биелүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Гурванбаян тосгоны 2026 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн багийн иргэдийн нийтийн хурлаар Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны ажлын тайланг хэлэлцэж 100 хувь буюу “Хангалттай” гэж үнэлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас 180,370.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 96,495.8 мянган төгрөгийн өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, эмчийн байр болон гүний худаг гаргах 77,379.8 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч компани оролцоогүйн улмаас хийгдээгүй байна. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох журмыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>414,071.07</b>	<b>280,690.75</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	164,331.87	122,926.32
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	41,533.92	63,012.98
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	113,827.5	1,745.77
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	94,377.78	93,005.68
<b>6</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>933,956.46</b>	<b>1,134,228.75</b>
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	933,956.46	1,134,228.75
8	1.2.2.02 Биет хөрөнгө		911,664.46	1,111,936.75
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	22,292	22,292
<b>10</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>1,348,027.53</b>	<b>1,414,919.5</b>
<b>11</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>143.89</b>	<b>11,683.63</b>
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		143.89	11,683.63
13	2.1.1.03 Өглөг		143.89	11,683.63
<b>14</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>1,347,883.63</b>	<b>1,403,235.87</b>
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		1,347,883.63	1,403,235.87
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		165,881.06	165,881.06
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		1,010,118.39	1,065,470.63
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		171,884.18	171,884.18
<b>19</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>1,348,027.53</b>	<b>1,414,919.5</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12- р сарын 31
1	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>1,066,167.28</b>	<b>1,377,034.81</b>
2	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>225,233.67</b>	<b>253,539.89</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		170,991.49	195,434.93
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		170,991.49	195,434.93
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		17,710.48	14,253.78
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		36,531.7	43,851.18
7	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>31,622.07</b>	<b>1,123,494.92</b>
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	601,979.91
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		809,311.54	0.0
10	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>1,108,801.13</b>	<b>1,113,354.99</b>
11	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,108,801.13</b>	<b>1,113,354.99</b>
12	<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,080,904.13</b>	<b>1,103,142.99</b>
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		360,323.62	431,080.02
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		43,943.56	52,856.21
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		296,162.94	310,555.09
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		40,203.6	37,882.78
17	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		27,730.7	41,262.86
18	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		12,228	7,575.7
19	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,085.69	1,905.32
20	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		292,226.03	220,025.02
21	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>27,897</b>	<b>10,212</b>
22	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>-42,633.85</b>	<b>263,679.81</b>
23	<b>1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>4,544.5</b>	<b>208,327.58</b>
24	<b>1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)- (V)</b>		<b>-4,544.5</b>	<b>-208,327.58</b>
25	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>-47,178.35</b>	<b>55,352.24</b>

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,395,061.98		1,395,061.98
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,395,061.98		1,395,061.98
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-47,178.35		-47,178.35
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,347,883.63		1,347,883.63
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,347,883.63		1,347,883.63
<b>6</b>	<b>1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,347,883.63</b>		<b>1,347,883.63</b>
<b>7</b>	<b>1.7 Тайлант үеийн үр дүн</b>	<b>55,352.24</b>		<b>55,352.24</b>
<b>8</b>	<b>1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>1,403,235.87</b>		<b>1,403,235.87</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,042,207.28</b>	<b>1,001,278.71</b>
2	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>225,233.67</b>	<b>253,539.89</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	170,991.49	195,434.93
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	17,710.48	14,253.78
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	36,531.7	43,851.18
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,423.2	3,475.36
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	29,108.5	40,375.82
8	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,401.07</b>	<b>747,738.82</b>
9	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	6,401.07	3,388.51
10	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	601,979.91
11	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	142,370.4
12	<b>1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>810,572.54</b>	<b>0.0</b>
13	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>848,909.17</b>	<b>926,188.4</b>
14	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>848,909.17</b>	<b>926,188.4</b>
15	<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>820,412.17</b>	<b>912,867.22</b>
16	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,558.98	427,439.3
17	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,114.45	53,276.78
18	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,042.94	304,208.93
19	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	31,299.15	21,919.06
20	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	2,539.97	1,500
21	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	30,666.2	41,375.8
22	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	12,228	7,395
23	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,865.69	5,660.34
24	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	28,096.8	50,092
25	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,497</b>	<b>13,321.19</b>
26	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>193,298.11</b>	<b>75,090.31</b>
27	<b>1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>140,436.13</b>	<b>96,495.85</b>
28	<b>1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>140,436.13</b>	<b>96,495.85</b>
29	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	140,436.13	96,495.85

30	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-140,436.13	-96,495.85
31	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	20,000
32	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-20,000
33	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	52,861.98	-41,405.54
34	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	111,469.88	164,331.87
35	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	164,331.87	122,926.32

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,806,258.80</b>	<b>1,769,068.69</b>	<b>37,190.11</b>
<b>11</b>	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	<b>251,200.00</b>	<b>253,539.89</b>	<b>(2,339.89)</b>
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	190,400.00	195,434.93	(5,034.93)
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	190,400.00	195,434.93	(5,034.93)
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	172,400.00	168,033.89	4,366.11
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	2,000.00	6,469.08	(4,469.08)
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	16,000.00	20,062.83	(4,062.83)
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	-	869.13	(869.13)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	23,700.00	14,253.78	9,446.22
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,200.00	4,496.68	(3,296.68)
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	500.00	540.00	(40.00)
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	22,000.00	9,217.10	12,782.90
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	37,100.00	43,851.18	(6,751.18)
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,100.00	3,475.36	(1,375.36)
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	400.00	1,260.00	(860.00)
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,700.00	2,215.36	(515.36)
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	35,000.00	40,375.82	(5,375.82)
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	35,000.00	40,375.82	(5,375.82)
<b>12</b>	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	<b>1,555,058.80</b>	<b>1,515,528.80</b>	<b>39,530.00</b>
<b>120</b>	<b>3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,600.00</b>	<b>3,088.51</b>	<b>511.49</b>
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	3,000.00	2,600.00	400.00
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	600.00	488.51	111.49
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,409,088.40	1,370,069.89	39,018.51
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	577,444.20	577,444.20	-
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	831,644.20	792,625.69	39,018.51
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	142,370.40	142,370.40	-
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	142,370.40	142,370.40	-
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,104,376.80</b>	<b>1,901,686.43</b>	<b>(797,309.63)</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>924,006.40</b>	<b>1,805,190.58</b>	<b>(881,184.18)</b>
<b>210</b>	<b>3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>913,711.40</b>	<b>888,590.70</b>	<b>25,120.70</b>
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,598.30	427,439.30	159.00
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	259,200.00	259,187.30	12.70
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	149,598.30	149,545.43	52.87

210103	3.1.01.2.1.1.1.03 хөнгөлөлт	Унаа хоолны	13,800.00	13,762.52	37.48
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	5,000.00	4,944.05	55.95
2102	3.1.01.2.1.1.2 даатгалд төлөх шимтгэл	Ажил олгогчоос нийгмийн	53,437.80	53,276.78	161.02
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	36,337.40	36,337.40	0.00
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	4,275.40	4,275.32	0.08
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	2,137.50	2,137.50	0.00
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	2,137.50	2,137.50	0.00
210205	3.1.01.2.1.1.2.05 даатгал	Эрүүл мэндийн	8,550.00	8,389.07	160.93
2103	3.1.01.2.1.1.3 холбоотой тогтмол зардал	Байр ашиглалттай	310,398.50	304,208.93	6,189.57
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	47,437.60	42,636.86	4,800.74
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	261,160.90	260,872.07	288.83
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	1,800.00	700.00	1,100.00
2104	3.1.01.2.1.1.4 материалын зардал	Хангамж, бараа	25,055.70	21,919.06	3,136.64
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	2,500.10	1,721.00	779.10
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	11,655.60	11,238.81	416.79
210403	3.1.01.2.1.1.4.03 интернэтийн төлбөр	Шуудан, холбоо,	8,000.00	7,870.65	129.35
210405	3.1.01.2.1.1.4.05 зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	Хог хаягдал	950.00	560.00	390.00
210406	3.1.01.2.1.1.4.06 элэгдэх, ахуйн эд зүйлс	Бага үнэтэй, түргэн	1,950.00	528.60	1,421.40
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	1,500.00	1,500.00	-
210503	3.1.01.2.1.1.5.03 зөөлөн эдлэл	Нормын хувцас,	1,500.00	1,500.00	-
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал	48,369.00	41,375.80	6,993.20
210601	3.1.01.2.1.1.6.01 хэрэгсэл	Багаж, техник,	15,035.00	10,540.00	4,495.00
210603	3.1.01.2.1.1.6.03 хэрэглэл	Хөдөлмөр хамгааллын	584.00	584.00	-
210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	32,750.00	30,251.80	2,498.20
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	9,000.00	7,395.00	1,605.00
210702	3.1.01.2.1.1.7.02 томилолт	Дотоод албан	9,000.00	7,395.00	1,605.00
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн	6,602.10	4,233.82	2,368.28
210801	3.1.01.2.1.1.8.01 хураамж	Бусдаар гүйцэтгүүлсэн	4,332.90	2,951.00	1,381.90
210802	3.1.01.2.1.1.8.02 баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	Аудит,	324.20	-	324.20
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	550.00	448.85	101.15
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн	250.00	248.81	1.19
210805	3.1.01.2.1.1.8.05 оношлогоо	Тээврийн хэрэгслийн	145.00	143.51	1.49
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл,	450.00	305.60	144.40
210807	3.1.01.2.1.1.8.07	технологийн үйлчилгээ	550.00	136.05	413.95
2109	3.1.01.2.1.1.9 бусад зардал	Газрын төлбөр	31,750.00	27,242.00	4,508.00

210901	3.1.01.2.1.1.9.01 бусад зардал	Бараа үйлчилгээний	29,750.00	25,242.00	4,508.00
210902	3.1.01.2.1.1.9.02 үйлдвэрлэлийн дадлага хийх	Хичээл	2,000.00	2,000.00	-
<b>213</b>	<b>3.1.01.2.1.4</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,295.00</b>	<b>916,599.89</b>	<b>(906,304.89)</b>
2131	3.1.01.2.1.4.1 шилжүүлэг	Засгийн газрын урсгал	-	906,387.89	(906,387.89)
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	906,387.89	(906,387.89)
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	10,295.00	10,212.00	83.00
213208	3.1.01.2.1.4.2.07 төрөөс үзүүлэх дэмжлэг	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад	8,712.00	8,712.00	-
213209	3.1.01.2.1.4.2.08 шагнал урамшуулал	Нэг удаагийн тэтгэмж,	1,583.00	1,500.00	83.00
<b>22</b>	<b>3.1.01.2.2</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>180,370.40</b>	<b>96,495.85</b>	<b>83,874.55</b>
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	180,370.40	96,495.85	83,874.55
<b>8</b>	<b>3.1.01</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ</b>	<b>701,882.00</b>	<b>(132,617.74)</b>	<b>834,499.74</b>
<b>9</b>	<b>3.1</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ</b>	<b>(701,882.00)</b>	<b>132,617.74</b>	<b>(834,499.74)</b>
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(701,882.00)	132,617.74	(834,499.74)
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	139,487.60	(139,487.60)
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	120,632.06	(120,632.06)

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
<b>1</b>	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>24,535.71</b>
<b>12</b>	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,535.71</b>
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	24,535.71
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	24,535.71
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	24,535.71
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,675.71
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,860.00
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>21,426.52</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,426.52</b>
<b>210</b>	<b>1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>21,426.52</b>
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,426.52
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,426.52
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	20,000.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	20,000.00
<b>4</b>	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>3,109.19</b>
<b>5</b>	<b>1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(3,109.19)</b>
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(3,109.19)

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Гурванбаян тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тосгоны 5 төсөвт байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгт “Платиниум прогресс аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт, аймаг дахь Төрийн аудитын газар Захирагчийн ажлын албаны санхүүгийн тайланд аудит хийж “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн. Соёлын төв, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн санг аудитын түүвэрт хамруулан үе шатны ажлыг хийж гүйцэтгэсэн.

#### **3.1 Тус тосгоны харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 399,066.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 378,182.9 мянган төгрөгийн 4 алдааг санхүүгийн тайланд залруулж, 791.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 20,092.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **Захирагчийн ажлын алба**

- 1. АЗДТГ-аас болон ОНХС-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 196,763.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүйгээс, Ном дансны дэлгэрэнгүй тайланд бүртгэлтэй 651.5 мянган төгрөгийн хөрөнгө байдлын тайланд бүрэн татагдаагүйгээс үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан. Үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгийг орлогод авч залруулав.*
- 2. Үнэ төлбөргүйгээр хүлээн авсан үндсэн хөрөнгийг орлогод авч санхүүгийн тайланд тусгаагүйгээс Авто тээврийн хэрэгсэл дансны элэгдлийн зардал 6,422.2 мянган төгрөгөөр, Бусад үндсэн хөрөнгө дансны элэгдлийн зардал 21,757.4 мянган төгрөгөөр тус тус санхүүгийн тайланд дутуу илэрхийлэгдсэн байна. Тайлант хугацааны элэгдлийн зардлыг нөхөн бодуулж залруулав.*
- 3. Ээлжийн амралттай 2 албан хаагчид 656.7 мянган төгрөгийн цалинг давхардуулан тооцож олгосон.*

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

- 4. Үндсэн үйл ажиллагааны цалингийн зардлаас олон нийтийн цагдаагийн цалинд 11,583.6 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас хувцас хэрэглэлд 1,500.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас цол ахиулан амжилт гаргасан бөхөд 1,500.0 мянган төгрөгийн мялаалга, хичээл үйлдвэрлэлийн зардлаас малчдын сургалт, сурталчилгаанд 2,000.0 төгрөгийг тус тус зарцуулж төсвийг зориулалт бусаар зарцуулсан.*

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

- 5. Байгууллагын хэрэгцээнд 2 төрлийн интернэт сүлжээг зэрэгцүүлэн ашиглаж 3,509.0 мянган төгрөгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан.*

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

#### **Орон нутгийн хөгжлийн сан**

- 1. Сангийн орлогын дансны ангилал зөрүүлэн бүртгээснийг нийт дүнгээр залруулав.*
- 2. Зээлийн хүүгийн авлагыг нийт дүнгээр бүртгээснийг санхүүгийн тайланд зээлийн хүүгийн авлага, үндсэн зээлийн авлагаар тусад нь тайлагнаж залруулав.*

### **3.2 Тус тосгоны харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 13,108.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 9,356.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 3,751.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

#### **Соёлын төв**

1. *Тайлант оны урсгал засварын зардлаас 3,751.2 мянган төгрөгийн техник хэрэгсэл худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.*

*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

#### **Ерөнхий боловсролын сургууль**

1. *Тайлант онд 4 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 8,081.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.*

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

#### **Эрүүл мэндийн төв**

1. *Тайлант онд 1 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 426.7 мянган төгрөгийн цалин, 3 ажилтанд 2024 оны ажлын үр дүнгийн үнэлгээгээр 848.4 мянган төгрөгийн урамшуулал, нийт 1,275.1 мянган төгрөг олгосон байна.*

*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.*

### **3.3 Тосгоны Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:**

Гурванбаян тосгоны Захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,681.4 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

1. *Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд замд яваа мөнгө 2,681.5 мянган төгрөгийг тусгаагүй байна.*

Аудитаар нийт 74,147.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 1,143.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 24,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 49,003.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүллээ.

#### **3.3.1 Төлбөрийн акт**

1. *ОНХС-ийн дансанд тайлант оны малын тоо толгойн албан татварыг 1,143.4 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.*

#### **3.3.2 Албан шаардлага**

1. *"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.13 дахь заалтыг зөрчиж 3 төсөл арга хэмжээнд 30%-иас дээш дүнгээр урьдчилгаа төлбөр олгосон байна.*

### **3.3.3 Зөвлөмж**

1. Сумын ИТХ-ын 2025 оны 22 дугаар тогтоолд малын тоо толгойн албан татварын орлогыг 22,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 9,217.1 мянган төгрөгийг төвлөрүүлж татварын орлого 12,782.9 мянган төгрөгөөр тасарсан байна.

**Өгсөн зөвлөмж:** Сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх.

**Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.**

2. ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг төлөвлөж батлаагүй, ХХС-ийн зээлийн үлдэгдлийн 63% болох 7 зээлдэгчийн 36,221.0 мянган төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд шилжсэн боловч зээлийг эргэн төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна

**Өгсөн зөвлөмж:** “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Мэдээллийг тусгажүй оржигдуулсантай холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗАА	2.0	225,594.3			2.0	225,594.3								
ОНХС	1.0	150,444.1					1.0	150,444.1						
ХХС	1.0	2,144.5			1.0	2,144.5								
<b>ОНБ-ын дүн</b>	<b>4.0</b>	<b>378,182.9</b>	-	-	<b>3.0</b>	<b>227,738.8</b>	<b>1.0</b>	<b>150,444.1</b>	-	-	-	-	-	-
ЕБС	-	-												
Цэцэрлэг	-	-												
Соёлын төв	-	-												
ЭМТ	-	-												
<b>УТБ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гурванбаян Захирагч	1.0	2,681.4					1.0	2,681.4						
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>1.0</b>	<b>2,681.4</b>	-	-	-	-	<b>1.0</b>	<b>2,681.4</b>	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>5.0</b>	<b>380,864.4</b>	-	-	<b>3.0</b>	<b>227,738.8</b>	<b>2.0</b>	<b>153,125.5</b>	-	-	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗАА	3.0	20,883.9	1.0	791.3	2.0	20,092.6							
ОНХС	-	-											
ХХС	-	-											
<b>ОНБ-ын дүн</b>	<b>3.0</b>	<b>20,883.9</b>	<b>1.0</b>	<b>791.3</b>	<b>2.0</b>	<b>20,092.6</b>	-	-	-	-	-	-	-
ЕБС	1.0	8,081.8	1.0	8,081.8									
Цэцэрлэг	-	-											
Соёлын төв	1.0	3,751.2			1.0	3,751.2							
ЭМТ	1.0	1,275.1	1.0	1,275.1									
<b>УТБ-ын дүн</b>	<b>3.0</b>	<b>13,108.1</b>	<b>2.0</b>	<b>9,356.9</b>	<b>1.0</b>	<b>3,751.2</b>	-	-	-	-	-	-	-
Гурванбаян Захирагч	4.0	74,147.2	1.0	1,143.4	1.0	24,000.0	2.0	49,003.8					
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>4.0</b>	<b>74,147.2</b>	<b>1.0</b>	<b>1,143.4</b>	<b>1.0</b>	<b>24,000.0</b>	<b>2.0</b>	<b>49,003.8</b>	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>10.0</b>	<b>108,139.1</b>	<b>4.0</b>	<b>11,291.6</b>	<b>4.0</b>	<b>47,843.8</b>	<b>2.0</b>	<b>49,003.8</b>	-	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗАА	-	-											
ОНХС	-	-											
ХХС	-	-											
<b>ОНБ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
ЕБС	-	-											
Цэцэрлэг	-	-											
Соёлын төв	-	-											
ЭМТ	-	-											
<b>УТБ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Гурванбаян Захирагч	-	-											
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	5	4	1		3	1		
2	ОНТС	2		2					
3	ТТЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>8</b>	<b>5</b>	<b>3</b>		<b>3</b>	<b>2</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 89-А2371281

Чингис хот

ХЭА-2026/011/НА-СТА-ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын орлогын 1,143,400.00 (Нэг сая нэг зуун дөчин гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх:", 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй." гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Малын тоо толгойн албан татварын 1,143,400.0 (нэг сая нэг зуун дөчин гурван мянга дөрвөн зуу) төгрөгийг Төрийн сан банк дахь ерөнхий орлогын 100181800910 тоот данснаас "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 100181852400 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг тосгоны Захирагч /Ж.Энххуяг/-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

*Н. Хэрлэнбаяр*

Ж.ГАНБААТАР  
Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 288-А2371281

Чингис хот

ХЭА-2026/011/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Гурванбаян тосгоны Захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 24,000,000.00 (хорин дөрвөн сая) төгрөгийн гурван төсөл арга хэмжээнд 30 хувиас дээш төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам-ын 4.8.13-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь барилга, байгууламжийн төслийн хувьд гэрээний үнийн дүнгийн 30 хувь хүртэл байх бөгөөд тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн дүнгээс ихгүй байна," гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилгаа төлбөрийг гэрээ болон журамд заасан хэмжээнээс хэтрүүлэн олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Захирагч /Ж.Энххуяг/-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР

